

**“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ
2022 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2022 оны 01 дүгээр сарын 31

Багануур дүүрэг

№	Үндэслэл	Хийсэн ажлын биелэлт	Гүйцэтгэл, хувь
1	2	3	4
1.	Байгууллагын 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 2.1.2	<ul style="list-style-type: none"> - Паркийн цахилгаан хангамжийн батлагдсан зураг төслийн хүрээнд 2022 онд эхлэх Паркийн ерөнхий цахилгаан хангамжийн 110 кВ-ын 6,76 км урт өндөр хүчдэлийн агаарын шугамыг барих асуудлаар МЕСЕС ХХК-тай 01 дүгээр сарын 05-ны өдөр уулзалт зохион байгуулж, 2020 оны 02 дугаар сарын 09-ний өдөр байгуулсан 20/02 тоот гэрээг дүгнэж, 7,3 км 110 кВ-ын ЦДӨХАШ-ын бүтээн байгуулалтыг эхлүүлэх бэлтгэл ажил болон хөрөнгө оруулалтын талаар хэлэлцсэн. - Мөн МЕСЕС ХХК-аас ирүүлсэн 01 дүгээр сарын 03-ны өдөр 001 дугаартай албан бичгээр дээрх хамтран хэрэгжүүлэх цахилгаан хангамжийн шугам барих ажлын нийт 3,922.6 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын манай байгууллагаас гарах 1,961.3 сая төгрөгийг хэрхэн төсөвт оруулах аргачлалыг тодорхойлох хүсэлтийн дагуу дараах ажлуудыг зохион байгуулж байна. <ul style="list-style-type: none"> ○ НЗДТГ-ын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн холбогдох мэргэжилтнүүдтэй хамтран ажиллаж хөрөнгө оруулалтыг хуулийн хугацаа болох 03 дугаар сарын 01-нээс өмнө хэрхэн зохицуулах, зохион байгуулах талаар уулзалт зохион байгуулж, ажлын төлөвлөгөө гаргаж байна. ○ Мөн паркуудын асуудлыг хариуцсан дээд шатны удирдлагуудтай дээрх асуудлын хүрээнд уулзалт зохион байгуулан ажиллаж байна. 	100
2.	Байгууллагын 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 2.3.3	Паркийн үндсэн нэгж Монхимо ХХК-ийн удирдлагатай 01 дүгээр сарын 17-ны өдөр цахимаар уулзалт зохион байгуулж 2021 оны үйл ажиллагаа, 2022 оны хөгжлийн бодлого, зорилт, тулгамдаж байгаа асуудлын талаар хэлэлцсэн.	100
3.	Байгууллагын 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 1.1.4	Байгууллагын 2022 оын Гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж, 01 дүгээр сарын 05-ны өдрийн 01 дугаартай албан бичгээр НЗДТГ-т хүргүүлсэн.	100
4.		Захиргааны болон Үйлдвэрлэл, технологийн албаны 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 01 дүгээр сарын 05-ны өдөр, нийт албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг 01 дүгээр сарын 10-ны дотор Газрын даргаар батлуулсан.	100
5.		Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд албан хаагчдын 2022 оны сургалтын төлөвлөгөө болон албан хаагчдын нийгмийн баталгааг хангах 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 01 дүгээр сарын 04-ний өдөр Газрын даргаар батлуулсан.	100

1	2	3	4
6.	Байгууллагын 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 1.1.4	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2022 оны төлөвлөгөөнд үндэслэн байгууллагын авлигын эсрэг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан 01 дүгээр сарын 10-ны өдөр, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах дүүргийн дэд хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх 2022 оны арга хэмжээний төлөвлөгөөг 01 дүгээр сарын 05-ны өдөр тус тус батлуулсан.	100
7.		Мөн Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөг боловсруулж байгаатай холбогдуулан НЗДТГ-аас ирүүлсэн салбарын танилцуулга, тусгуулах төсөл, хөтөлбөрийн санал, түүний тайлбар, тус санал ЗГ-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан эсэх бүхий хавсралтыг боловсруулж, НЗДТГ болон нийслэлийн Бизнес, инноваци хөгжлийн газрын холбогдох мэргэжилтнүүдийн ERP хаягт тус тус хүргүүлсэн.	100
8.	Байгууллагын 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 1.2.1	Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найрууллагын хүрээнд албан хаагчдын хөдөлмөрийн гэрээг шинэчлэн боловсруулж байна.	40
9.		<ul style="list-style-type: none"> - Байгууллагын албан хаагч нартай холбоо барих мэдээллийг 2022 оны 01 дүгээр сарын байдлаар гаргаж байгууллагын цахим хуудсанд байршуулсан. - Одоогоор ажлаас чөлөөлөгдсөн болон шинээр ажилд томилогдсон албан хаагч байхгүй. 	100
10.	Байгууллагын 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 1.2.4	<ul style="list-style-type: none"> - Төрийн албаны Зөвлөлөөс 2022 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр зохион байгуулсан “7:4:10” арга зүйн сургалтад бүх албан хаагчид цахимаар хамрагдсан. - 2022 оны 01 дүгээр сарын 07-ны өдөр шилэн дансны сургалтад Нягтлан бодогч хамрагдсан. - 2022 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр Багануур дүүргийн ЗАА, Нийслэлийн Үндэсний цэцэрлэгт хүрээлэн ОНӨТҮГ-тай хамтран зохион байгуулсан “Мод тарих арга технологи, арчлах аргачлал”-ын сургалтад Үйлдвэрлэл, технологийн албаны Ахлах мэргэжилтэн, Үйлдвэрлэл, технологийн кластер инженер нар хамрагдсан. - 2021-2022 оны хичээлийн жилд хамрагдах сургалтын саналыг боловсруулж, 01 дүгээр сарын 25-ны өдрийн 04 дугаартай албан бичгээр Албан бус-Насан туршийн боловсролын төвд хүргүүлсэн. - Төрийн албаны Зөвлөлөөс 01 дүгээр сарын 27-ны өдөр зохион байгуулсан “Орчин үеийн хөгжлийн мегатрендүүд” сургалтад Захиргааны албаны Ахлах мэргэжилтэн хамрагдсан. - 01 дүгээр сарын 24-ний өдөр дүүргээс зохион байгуулсан ХХОАТ-ын тайлангийн цахим сургалтад Нягтлан бодогч хамрагдсан. 	100
11.	Байгууллагын 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 1.3.2	<ul style="list-style-type: none"> - 2021 онд үүсч хөтлөгдсөн баримт бичгийг албан хаагчдаас хүлээж авах төлөвлөгөөг 2022 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр батлуулсан. Төлөвлөгөөний дагуу албан хаагч нар баримтаа архивлахад бэлтгэж байна. - Байгууллагын 2021 оны Архивын ажлын төлөвлөгөөг батлуулж, ажилтнуудад танилцуулсан. - 2022 оны үйл ажиллагааны явцад хөтлөгдөх Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг мэргэжилтнүүдээс санал авч нэгтгэн гаргасан. 	100

1	2	3	4
12.	Байгууллагын 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 1.3.4	<ul style="list-style-type: none"> - “Хүний нөөцийн удирдлагын дэд систем”-д байгууллагын нэгж, албан тушаал, албан хаагчдын хувийн хэрэг болон ээлжийн амралтын мэдээллийг тухай бүрт нь шинэчлэн ажилладаг. - “Цаг бүртгэлийн дэд систем”-д ажилчдын цаг ашиглалт, цахим төлөв, ээлжийн амралт, гадуур ажил, бүх нийтийн амралтын өдрүүдийн мэдээллийг тухай бүрт нь бүртгэлжүүлэн ажилладаг ба тайлант сард цар тахалтай холбоотой Улс, нийслэлийн Онцгой комиссын шийдвэрийн хүрээнд 5 албан хаагчийн цахим цаг бүртгэлийг тус дэд системд бүртгэлжүүлэн ажилласан. - “Мэдэгдэл дэд систем”-д тавигдсан мэдээлэлтэй албан хаагчид тухай бүр танилцан ажиллаж байна. - “Ажлын хэсэг, хурал, уулзалт, үүрэг даалгавар дэд систем”-д тайлант сард 1 үүрэг даалгавар удирдлагаас холбогдох албан хаагчдад хуваарилагдсан. - Иргэн албан хаагчаас гаргасан өргөдлийг “Өргөдөл гомдлын дэд систем”-д тухайн өргөдлийн шинж чанараас хамааран албан хаагчдаас ирсэн өргөдлийн ангилалаар бүртгэж цаг тухайд нь даргын тушаалаар шийдвэрлэн хариуг холбогдох эзэнд нь даруй мэдээлж ажилладаг. Тайлант сард иргэн, албан хаагчаас ирсэн өргөдөл, гомдол байхгүй. - “Үйл явдлын дэд систем”-д тавигдсан мэдээлэлтэй албан хаагчид тухай бүр танилцан ажиллаж байна. Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/1033 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн Хотын стандарт, хяналтын газраас 22 бүлэг сэдвийн хүрээнд боловсруулсан 97 төрлийн хотын стандартын баримт бичгүүдээс эхний 38 баримт бичигт холбогдох төсөлд нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын албан хаагчид, мэргэжлийн байгууллага, иргэд, олон нийтээс санал асуулга авч байгаатай холбогдуулан байгууллагын албан хаагчдыг саналд хамруулсан. - “Албан хэрэг хөтлөлтийн едос дэд систем”-ээр: <ul style="list-style-type: none"> ○ Тайлант сард хариутай 2, хариугүй 11 нийт 13 албан бичиг ирсэн. Албан бичгийн шийдвэрлэлт, хаалт тус бүр 100%. Шийдвэрлэлтийн дундаж хугацаа 1.85 хоног. ○ “Багануур үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨТҮГ-аас тайлант сард нийт 5 албан бичиг нийслэл, дүүргийн газар, хэлтсүүдэд явуулсан. Шийдвэрлэлт 100%. 	100
13.	Байгууллагын 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 1.6.1	<p>Байгууллагын цахим хуудасны хөтлөлтийг тогтмол хийж, мэдээллийг шинэчлэн ажиллаж байна. Тайлант сард нийт 85 мэдээллүүдийг байршуулан ажилласан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 9 - Монгол бичгийн мэдлэг, мэдээлэл түгээх чиглэлээр 32 - Байгууллагын үндсэн чиглэлтэй холбоотой цаг үеийн мэдээлэл 4 - Байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд 10 - Байгууллагад мөрдөгдөж байгаа шинэ хууль эрх зүй, тогтоол, захирамж 2 - Хүний нөөцийн чиглэлээр 2 - Ковид цар тахалтай холбоотой зөвлөмж 20, шийдвэр 7 	100

1	2	3	4
14.	Байгууллагын 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 4.1.1	<ul style="list-style-type: none"> - 2021 оны санхүүгийн тайлан тэнцэлийг гаргасан. - 2022 оны төсвийн хуваарийн дагуу 01 дүгээр сарын санхүүгийн гүйлгээг зохих журмын дагуу хугацаанд нь хийлгэсэн. 	100
15.	Байгууллагын 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 4.1.8	www.shilendans.mn сайтанд байгууллагын санхүүгийн мэдээллийг агуулга стандартын дагуу байршуулж байна.	100
16.	Байгууллагын 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 7.1.3	<p>Нийслэлийн Онцгой комиссын даргын 01 дүгээр сарын 05-ны өдрийн 07 тоот албан бичгийн хавсралтаар батлагдсан “Төр хувийн хэвшлийн байгууллагад коронавируст халдвараас сэргийлэх, тохиолдол илэрсэн үед авах арга хэмжээний түр зөвлөмжийн дагуу дараах арга хэмжээнүүдийг авч халдвар хамгааллын дэглэмийг баримтлан ажиллаж байна. Үүнд:</p> <p><u>Байгууллагын дотоод зохион байгуулалтын хүрээнд:</u></p> <ul style="list-style-type: none"> - Ажилтнуудыг ажлын байранд нэвтрэхээс өмнө түрээслүүлэгч компанийн ажилтан биеийн халууныг хэмжиж, гарыг халдваргүйжүүлж байна. - Ажилчдыг паркийн үндсэн нэгж Монхимо ХХК-ийн гар ариутгах болон ам хоолой зайлах уусмалаар тогтмол хангаж байна. - Ажлын байранд хүний гар хүрэх газрыг 2 цаг тутамд ариутгаж, өдөр бүр агааржуулалтыг хийн, 7 хоногт нэг удаа их цэвэрлэгээг зохион байгуулан ажиллаж байна. - Иргэдийн зорчих хөдөлгөөний мэдээллийг бүртгэх QR кодыг иргэдийн орох хэсэгт ил харагдахаар байршуулан хэрэгжилтэнд шууд хяналт тавьж байна. <p><u>Түр зөвлөмжийн хүрээнд:</u></p> <ul style="list-style-type: none"> - 1.1. Коронавируст халдвараас сэргийлэх талаар ЭМЯ-наас бэлтгэсэн зурагт хуудас, зөвлөмжийг мэдээллийн самбарт байршуулан ажиллаж байна. - 1.2. Албан хаагчид амны хаалтыг тогтмол зүүж байгаа ба бохирдсон даруйд сольж байна. - 1.3. Албан хаагчид 1-2метрийн зайг баримтлан ажил үүргээ гүйцэтгэж байгаа ба ажлын байранд хамтарч хооллох, цай уух зэргээр бөөгнөрөл үүсгэхгүй, ойроос харьцахгүй ажиллаж байна. - 1.4. Албан хаагчдыг гар угаах болон халдваргүйжүүлэх нөхцөлөөр ханган ажиллаж байна. Мөн байгууллагад шаардлагатай цэвэрлэгээний материал, холермин зэргээр хангаж, аюулгүй орчинг бүрдүүлэн ажиллаж байна. - 1.5. Ажлын байранд гадны хүн оруулахгүй байгаа ба иргэд, хөрөнгө оруулагчдад паркийн үйл ажиллагаа, эрх зүйн хүрээний асуудлын мэдээллийг цахим хуудас, утсаар хүргэн ажиллаж байна. Гадны хүн орох шаардлагатай тохиолдолд QR кодыг уншуулан 1-2м зайг баримталж байна. - 1.6. Ажлын цагаар түрээслүүлэгч компанийн бусад өрөөнүүдээр орохгүй, байгууллагад эрсдэл учруулахгүй ажил үүргээ явуулж байна. 	100

1	2	3	4
17.	Байгууллагын 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 7.1.3	<ul style="list-style-type: none"> - 1.7. Ажлын байранд өдөр бүр 5-10 минутын агаар сэлгэлтийг хийж байна. - 1.8. Ажлын байранд нано, манангаар атомжуулагч ариутгалын төхөөрөмжөөр өрөө тасалгаануудыг халдваргүйжүүлж байна. - 1.9. Байгууллагын нийт 10 албан хаагчаас ковид-19 халдвараас сэргийлэх дархлаажуулалтын 1-р тунд - 10, 2-р тунд - 8, 3-р тунд – 6 хүн хамрагдсан. - 1.10. албан хаагчдынхаа дархлааг дэмжих зорилгоор тайлант сард байгууллагын Гэр бүл, хүүхэд, залуучуудын салбар зөвлөлөөс “Халуун аарц” аяныг зохион байгуулан ажилласан. - 1.11. Албан хаагчид айл хэсэхгүй, зочин урихгүй, гэр-ажил-гэр маршрутыг баримтлан ажиллаж байна. Ковид-19 халдвар дахин авсан болон бүртгэгдсэн тохиолдол байхгүй. - Нийслэлийн Онцгой комиссын 2022 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 03 дугаартай албан бичгээр өгсөн “Коронавируст халдварын голомтын халдваргүйжүүлэлтийг байгууллагын зардлаар хийх” шийдвэрийг албан хаагчдад танилцуулсан. <p>Улсын Онцгой комиссоос гаргасан шийдвэрүүдийн хүрээнд тайлант сард нийт 5 албан хаагчийг тодорхой хугацаанд цахимаар ажиллуулахаар зохион байгуулалтын арга хэмжээг авсан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Улсын Онцгой комиссын 01 дүгээр сарын 10-ны өдрийн 01 дүгээр хурлын тэмдэглэлийн 1.3 дахь заалтын хүрээнд: 1 албан хаагч - Ойрын хавьтал болон биеийн байдлын улмаас 01 дүгээр сарын 17-ны өдрөөс эхлэн 14 хоногийн хугацаагаар, 2 албан хаагч – Тусгаарлалтад 01 дүгээр сарын 19-ны өдрөөс эхлэн 7 хоногийн хугацаагаар - Улсын Онцгой комиссын Шуурхай ажлын хэсгийн 01 дүгээр сарын 14-ний өдрийн 01 дүгээр хурлын тэмдэглэлийн 10 дахь заалтын хүрээнд: 2 албан хаагч – 0-5 насны хүүхэдтэй эцгийг, 01 дүгээр сарын 17-ны өдрөөс эхлэн 1 сарын хугацаанд <p>Нийслэлийн Онцгой комиссын Шуурхай штабын 2022 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 02 дугаар хурлын тэмдэглэлийн 4.1 дэх заалтын дагуу 0-5 насны хүүхэдтэй 4 албан хаагчаас 2 ажилтанг 01 дүгээр сарын 17-ны өдрөөс цахимаар ажиллуулж байгаа тоон мэдээг 01 дүгээр сарын 21-ний өдөр хугацаанд нь nok@ulaanbaatar.mn хаягт хүргүүлсэн.</p>	100
НЭМЭЛТ АЖИЛ			
18.	Байгууллагын 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 1.2.13	<ul style="list-style-type: none"> - Үндсэн үйл ажиллагааны хүрээнд ирсэн ЗГ-ын 01 дүгээр сарын 05-ны өдрийн 07 дугаар тогтоол, Ковид цар тахалтай холбогдон гарсан УОК-ын Шуурхай ажлын хэсгийн 01 дүгээр сарын 14-ний өдрийн 01 дүгээр хурлын тэмдэглэл, НОК-ын Шуурхай штабын 01 дүгээр сарын 20-ны өдрийн 02 дугаар цахим хурлын тэмдэглэл, ЗГ-ын 01 дүгээр сарын 05-ны өдрийн 01 дүгээр тогтоол зэргийг албан хаагчдад танилцуулан хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. - Мөн албан хаагчдын ажлын гүйцэтгэлд хяналт тавин ажиллаж байна. 	100

1	2	3	4
19.	Байгууллагын 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 2.1.1	- 2022 онд Паркийн үндсэн 110кВ-ын өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах 6,76км урт агаарын шугамыг барих ажил эхлэхтэй холбогдуулан НИТХ-ын чуулганаар нийслэлийн 2022 оны төсөвт тусгагдсан 1,174.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын асуудлаар НЗДТГ-ын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлт хариуцсан Х.Азжаргал мэргэжилтэнтэй холбогдож мэдээлэл солилцож зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллаж байна. Одоогоор 2022 онд хийгдэх хөрөнгө оруулалтын ажлууд НЗД-ын захирамжаар батлагдахаар бэлтгэгдэж байна.	100
20.	Байгууллагын 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 2.3.3	<ul style="list-style-type: none"> - Байгууллагын цахим хуудсаар дамжуулан паркаас үзүүлэх хөнгөлөлт, урамшуулал, хууль эрх зүйн орчны талаарх мэдээллийг сонирхсон иргэд, хөрөнгө оруулагчдад хүргэж байна. - Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд Багануур дүүргийн Цагдаагийн хэлтсээс хүүхдийг болзошгүй осол гэмтлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан “Намайг анхаараарай” хэсэгчилсэн арга хэмжээний дагуу 01 дүгээр сарын 24-ний өдөр байгууллагын албан хаагчдад хүүхдийн ахуйн осол болон гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаарх зөвлөмж, дүүргийн хэмжээнд гарч буй осол гэмтэл, гэмт хэргийн зөрчлийн тоон мэдээллийг хүргэж ажилласан. <ul style="list-style-type: none"> ○ Тус арга хэмжээний хүрээнд “Багануур дүүрэг дэх Цагдаагийн хэлтэс” фейсбүк хуудсанд тавигдсан мэдээлэл, зөвлөмж, видео зэрэгтэй албан хаагчид цахимаар танилцаж, мэдээллүүдийг товч байдлаар бэлтгэн байгууллагын цахим хуудсаар дамжуулан олон нийтэд хүргэсэн. Байршуулсан мэдээллийн тоо – 7, мэдээллийг уншсан тоо – 21. ○ Мөн “Осол ойроос” уриалгыг бэлтгэн байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулсан. - Дээрх арга хэмжээний хүрээнд хийсэн ажлын тайланг 01 дүгээр сарын 25-ны өдрийн 05 дугаартай албан бичгээр дүүргийн Цагдаагийн хэлтэст, sukheebaasanjav2019@gmail.com хаягт тус тус хүргүүлсэн. 	100
УДИРДЛАГААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТ			
21.	Байгууллагын 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 1.2.13	Тайлант сард зохион байгуулагдсан 01 дүгээр сарын 10, 24-ний өдрийн нийслэлийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөн дээр нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг 01 дүгээр сарын 20, 31-ний өдөр www.old.ulaanbaatar.mn сайтад хугацаанд нь тайлагнан ажилласан. Багануур дүүргийн Засаг даргын 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/03 дугаар захирамжаар батлагдсан "Дүүргийн удирдах албан тушаалтнуудын 2022 оны шуурхай зөвлөгөөний хуваарь"-ийг удирдлагад танилцуулсан.	100
22.		01 дүгээр сарын 25-ны өдрийн дүүргийн удирдах ажилтнуудын шуурхай хуралдааны үеэр дүүргийн Засаг даргаас өгсөн үүрэг даалгаврыг албан хаагчдад танилцуулж, холбогдох арга хэмжээний биелэлтийг 01 дүгээр сарын 31-ний өдрийн 06 дугаартай албан бичгээр дүүргийн ЗДТГ-ын Худалдаа, үйлчилгээний хэлтэст, sharkishak31@gmail.com хаяг болон тус хэлтсийн Дэд бүтцийн асуудал хариуцсан мэргэжилтний ERP хаягт тус тус хүргүүлсэн.	100

1	2	3	4
23.	Байгууллагын 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 1.2.13	Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн хуралдааны 65 дугаар тэмдэглэлээр Хот, хөдөөгийн сэргэлтийн цогц төлөвлөгөөг боловсруулж, танилцуулахыг нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчид даалгасны дагуу төлөвлөгөөнд тусгах, хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг НЗДТГ-ын 01 дүгээр сарын 14-ний өдрийн 07/225 дугаартай албан бичгээр ирсэн хавсралтын дагуу боловсруулж, танилцуулгын хамт 01 дүгээр сарын 17-ны өдрийн 02 дугаартай албан бичгээр НЗДТГ-ын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст, файлыг тус хэлтсийн Замын хөдөлгөөн, нийтийн тээврийн бодлого, төлөвлөлт хариуцсан мэргэжилтний ERP хаягт тус тус хүргүүлсэн.	100
24.		НЗД-ын 2022 оны "Байгууллагуудын үйл ажиллагааны үр дүнг үнэлэх тухай" А/08 дугаар захирамжийн 1, 2, 3 дугаар хавсралтаар тус бүр батлагдсан ажлын хэсгийн бүрэлдэхүүн, удирдамж, үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлт зэргийг албан хаагчдад танилцуулсан. Байгууллагын 2021 оны үйл ажиллагааны танилцуулгыг бэлтгэж, 01 дүгээр сарын 20-ны өдөр НЗДТГ-ын И.Баатархүү ахлагчтай үнэлгээний багт танилцуулан байгууллагын 2021 оны үйл ажиллагааг шалгуулсан.	100
25.		Багануур дүүргийн ЗАА-наас өгсөн үүрэг даалгаврын дагуу Цагаан сарын баярыг угтсан бүх нийтийн их цэвэрлэгээг 2022 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр зохион байгуулж, тайланг 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 03 дугаартай албан бичгээр дүүргийн ЗАА-нд, baganuurzaa@gmail.com хаягт тус тус хүргүүлсэн.	100

ХЯНАСАН:
БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛТ ТЕХНОЛОГИЙН ПАРК
ОНӨТҮГ-ЫН ДАРГА



Ч. ЭЛБЭГСАЙХАН

БИЕЛЭЛТ НЭГТГЭСЭН
ЗАХИРГААНЫ АЛБАНЫ
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Э.ЭНХЗАЯА